



OMNI  
ASSET

# “ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юу Эй Эф Ассет Менежмент ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)  
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот  
Утас: +976-70122346

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

А.Батболд /"Омни Ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/

## **Агуулга**

---

1. ХБҮЦ-ны мэдээлэл .....	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл .....	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл .....	6



## 1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Омни Ассет ТЗК" ХХК нь 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Омни Капитал ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Омни Ассет ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар А.Батболд, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Х.Хэрлэн, ТУЗ-ийн хараат гишүүнээр С.Нина нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК ажиллаж байна.

"Омни Ассет ТЗК" ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 6.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

### Хүснэгт 1. ХБҮЦ-НЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Омни Ассет ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011851823
Регистрийн дугаар	8356327
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2023/11/08
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	552
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	60,000
ХБҮЦ (сая төг.)	6,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	19.6%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

"Омни Ассет ТЗК" ХХК нь ХБҮЦ-ны төлбөрийг Хүснэгт 2-т харуулсан хуваарийн дагуу төлнө.

### Хүснэгт 2. ХБҮЦ-НЫ ТӨЛӨЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Огноо	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үлдэгдэл
1	2024/02/28	-	296,416,438.36	6,000,000,000.00
2	2024/05/28	-	289,972,602.74	6,000,000,000.00
3	2024/08/28	-	296,416,438.36	6,000,000,000.00
4	2024/11/27	3,000,000,000.00	293,194,520.55	3,000,000,000.00
5	2025/02/28	-	149,819,178.08	3,000,000,000.00
6	2025/05/28	-	143,375,342.47	3,000,000,000.00
7	2025/08/28	-	148,208,219.18	3,000,000,000.00
8	2025/11/27	3,000,000,000.00	146,597,260.27	-
<b>Нийт</b>		<b>6,000,000,000.00</b>	<b>1,764,000,000.01</b>	<b>-</b>



## 2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант хугацааны байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 7.16 хувиар буурсан байна.

*Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар*

Хөрөнгийн багцын шинж чанар	2023.11.28	2023.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	6,000,003,341.98	5,570,585,552.13	-7.16%
Зээлийн дундаж үлдэгдэл	17,804,164.22	17,246,394.90	-3.13%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	2.89%	2.99%	0.11%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	10.76%	13.69%	2.94%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	36.34%	36.33%	-0.01%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	57.01%	55.47%	-1.54%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	8.85	9.93	12.14%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	26.40	25.51	-3.36%
Сарын дундаж төлбөрийн дүн	1,071,486.83	1,071,152.91	-0.03%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	5,188,086.25	5,263,505.41	1.45%
Зээлийн тоо /нийт/	337	323	-4.15%
<i>Иргэн</i>	336	322	-4.17%
<i>Хуулийн этгээд</i>	1	1	0.00%
Барьцаа хөрөнгийн үнэлгээ /нийт/	11,725,220,000.00	11,252,920,000.00	-4.03%
<i>Үл хөдлөх</i>	2,790,700,000.00	2,790,700,000.00	0.00%
<i>Автомашин</i>	8,934,520,000.00	8,462,220,000.00	-5.29%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	2.63%	2.63%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	-	601,949,694.31*	
<i>Зээлийн үндсэн төлбөр</i>	-	410,582,090.50	
<i>Хүүгийн төлбөр</i>	-	190,944,913.52	
<i>Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр</i>	-	422,690.29	

\*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2023 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 522.21 сая төгрөгийг гэрээний дагуу 2024 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Омни Ассет ТЗК" ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 99.06 сая төгрөг, хадгаламжийн хүү 14.5 хувь, харилцах дансны үлдэгдэл 2.73 сая төгрөг байна.



Тайлант хугацаанд "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь "Омни Ассет ТЗК" ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам"-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

*Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл*

<b>№</b>	<b>Өөрчлөлт орсон мэдээлэл</b>	<b>Зээлийн тоо</b>	<b>Зээлийн дүн</b>
1	Хаагдсан	13	-
2	Хугацаа хэтэрсэн тул буцаан шилжүүлсэн	1	18,835,699.35
3	Багцад нэмж бүртгэсэн	-	-
<b>Нийт</b>		<b>14</b>	<b>18,835,699.35</b>

### 3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Омни Ассет ТЗК” ХХК-ийг “Омни Капитал ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Омни Капитал ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭХ-23/003 тоот шийдвэрээр А.Батболд, С.Нина, Х.Хэрлэн нарыг ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн А.Батболдыг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 8 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

#### Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2023.05.23	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох тухай Журам батлах тухай	Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар хараат бус гишүүн А.Батболдыг томилов.  “Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй холбоотой хуулийг хэрэгжүүлэх журам” болон Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам”-ыг батлав.
2	2023.07.25	Тусгай зориулалтын компанийн үйл ажиллагааны журмуудыг батлах тухай  Хөрөнгийн багц худалдан авах, хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг батлах тухай  ХБҮЦ гаргах, түүний нөхцлийг тогтоох тухай  Санхүүгийн тайланд аудит хийх аудиторыг сонгон батлах тухай  Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай  Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох тухай	“ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам”, “Эрсдэл, сонирхлын зөрлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”, “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”, “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам” болон “Үнэт цаасны төлбөр төлөх, төлбөр цуглуулах журам”-ыг тус тус батлав.  Хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг баталж, багц худалдан авахтай холбоотойгоор гэрээ байгуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгов.  ХБҮЦ-ны ерөнхий нөхцөлийг батлав.  Аудит хийлгэхээр “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК-ийг сонгож, гэрээ байгуулав.  Оролцогч талуудтай гэрээ байгуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгов.  Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК-ийг сонгож, гэрээ байгуулав.



№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
3	2023.08.03	ХБҮЦ-ны танилцуулга батлах тухай	ХБҮЦ-ны танилцуулгыг батлав.
4	2023.08.23	ТЗК-ийн үйл ажиллагааны журмуудыг батлах тухай	ТЗК-ийн журмуудыг шинэчлэн батлав.
5	2023.08.23	Хөрөнгийн багц худалдан авах, хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг батлах тухай	Хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлав.
		ХБҮЦ гаргах, түүний нөхцлийг тогтоох тухай	ХБҮЦ-ны ерөнхий нөхцөлийг батлав.
		Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай	Оролцогч талуудтай гэрээ байгуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгосны дагуу гэрээг байгуулав.
6	2023.11.16	ХБҮЦ-ны танилцуулга батлах тухай	ХБҮЦ-ны танилцуулгын сүүлийн хувилбарыг баталж, СЗХ-нд хүргүүлэв.
		Тогтоол хүчингүй болгох тухай	ТУЗ-ийн 2023.07.25-ны өдрийн зарим тогтоол болон 2023.08.03-ны өдрийн тогтоолыг хүчингүй болгов.
		Үнэт цаасны данс нээх тухай	ТЗК нэр дээр ҮЦТХТ-д данс нээв.
7	2023.11.23	ХБҮЦ-ны бүртгэлийн гэрээ байгуулах тухай	МХБ-тэй гэрээ байгуулав.
7	2023.11.23	Данс захиран зарцуулах эрх олгох тухай	Богд банкинд хадгаламжийн данс нээлгэв.
8	2023.12.14	Данс захиран зарцуулах этгээдийг томилох тухай	ТЗК-ийн дансны захиран зарцуулах, гарын үсэг зурах этгээдээр Хөрөнгө итгэмжлэн удирдах "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийг томилов.
		Эхлэлийн зардал барагдуулах тухай	ХБҮЦ гаргахтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчээс гаргасан зардлыг хүлээн зөвшөөрч, зардлыг барагдуулав.